



**БУЛГАН АЙМГИЙН САЙХАН СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2015 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 1199

Их хүрэмт

Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг,  
оношлогоо явуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.е, Авто тээврийн тухай хуулийн 7.1.1, 17.1, 17.2, Авто замын тухай хуулийн 6.1.4, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 7.1, Татварын ерөнхий хуулийн 71.6.1, Аймгийн Засаг даргын 2015 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/78 дугаар тоот захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогоо явуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Тус суманд бүртгэлтэй бүх төрлийн тээврийн хэрэгслийн улсын үзлэг, тооллогыг 2015 оны 05 дугаар сарын 22-24-ны хооронд зохион байгуулсугай.

3. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдолын төлбөрийг хуульд заасан хугацаанд хурааж, улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлж ажиллахыг Татварын Улсын байцаагч /Г.Энхтуяа/ -д үүрэг болгосугай.

4. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэгт сум, багийнхаа бүх төрлийн тээврийн хэрэгслийг бүрэн хангуулж ажиллахыг ажлын хэсэг /Ч.Дэмбэрэлдорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Н.МЭНД-АМАР

My document Zahiramj